

XX зууны Монголын зурагт хуудасны монгол бичгийн хэрэглээний семиотик шинжилгээ

Тогтохын Оюун-Эрдэнэ 

Хүрээ Мэдээлэл Холбоо Технологийн Дээд Сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ oyunerdene@huree.edu.mn

Хураангуй: XX зууны монголын зурагт хуудас нь тухайн үеийн нийгэм, улс төр, соёлын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ визуал соёлын хөгжлийг илэрхийлсэн дүрслэх урлагийн чухал эх сурвалж юм. Энэхүү судалгаанд 1921-2000 онд бүтээгдсэн монгол бичиг бүхий 60 зурагт хуудсыг сонгон авч, Чарльз Моррисийн семиотикийн гурвалсан загварыг (синтактик, семантик, прагматик) онолын үндэс болгон монгол бичгийн үсгийн хэлбэр, зохиомж, өнгөний шийдэл, хэвлэлийн технологийн онцлогийг шинжилсэн болно.

Судалгааны үр дүнгээс харахад монгол бичгийн босоо бичлэг нь зурагт хуудасны зохиомжид нөлөөлж, текстийг дүрслэлийн элементтэй уялдуулан байрлуулах өвөрмөц боломжийг бүрдүүлж байжээ. Үсгийн тиг, өнгөний хэрэглээ болон хэвлэлийн технологийн хөгжил нь тухайн цаг үеийн нийгэм, соёлын нөхцөл байдалтай уялдан хувьсан өөрчлөгдөж байсан бөгөөд монгол бичгийн типографи нь улс төрийн үзэл суртал, үндэсний соёлын бэлгэдэл, түүхэн ой санамжийг илэрхийлэх чухал хэрэгсэл болж байв. Түүнчлэн судалгаанд ашигласан зурагт хуудасны тодорхой хэсэгт үсгийн хэлбэрийг дүрслэлийн элементтэй нэгтгэн ашигласан нь монгол бичгийн дүрслэлийн өргөн боломжийг харуулж байна.

Энэхүү судалгаа нь монгол бичгийн типографийг семиотикийн үүднээс тайлбарлах онолын хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ монголын визуал соёл, график дизайны түүхийг судлах шинэ өнцөг дэвшүүлж, орчин үеийн хос бичгийн хэрэглээ болон график дизайны практикт ашиглах боломжтой суурь мэдээллийг бүрдүүлж буйгаараа ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: *типографи, визуал соёл, дүрслэлийн хэл, тэмдэгтийн тогтолцоо, график дизайн*

A Semiotic Analysis of Mongolian Script Typography in 20th Century Posters

Oyun-Erdene Togtokh 

Huree University of Information and Communication Technology,
Ulaanbaatar, Mongolia

✉ oyunerdene@huree.edu.mn

Abstract: Twentieth-century Mongolian posters represent an important form of visual culture that not only disseminated the social, political, and cultural ideologies of their time but also reflected the development of modern Mongolian visual communication. This study examines 60 posters featuring the traditional Mongolian script produced between 1921 and 2000. Drawing on Charles Morris's triadic model of semiotics (syntactics, semantics, and pragmatics), the research analyzes the formal characteristics, compositional structures, color usage, and printing technologies of Mongolian-script typography.

The findings indicate that the vertical writing system of the Mongolian script significantly influenced poster composition by creating distinctive relationships between text and visual elements. Changes in typefaces, color schemes, and printing technologies corresponded closely with broader social and cultural transformations across the twentieth century. Mongolian-script typography functioned not only as a means of conveying information but also as a visual device for expressing political ideologies, cultural values, and collective historical memory. In addition, the integration of letterforms with pictorial elements in several posters demonstrates the expressive and symbolic potential of Mongolian script within graphic design.

This study contributes to the theoretical understanding of Mongolian-script typography from a semiotic perspective and offers a new approach to the study of Mongolian visual culture and graphic design history. The findings also provide a useful foundation for future research and contemporary design practices related to the use of Mongolia's dual-script system.

Keywords: *typography, visual culture, visual language, semiotic system, graphic design*

Оршил

Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон нь нийгэм, улс төрийн шинэчлэлийн эхлэлийг тавьж, улмаар хэвлэл мэдээллийн салбар эрчимтэй хөгжих үндэс болсон юм. 1912 онд “Орос Монгол хэвлэлийн хороо” байгуулагдаж, “Их хүрээний сонин бичиг”, “Шинэ толь” зэрэг тогтмол хэвлэлүүд гарч эхэлсэн байна (Батбаяр 2015, 166). Энэ нь монголын орчин үеийн хэвлэлийн түүхийн эхлэл болж, бичиг үсгийн соёлыг олон нийгэд түгээхэд томоохон түлхэц өгчээ. Үүний үр дүнд сонин, сэтгүүлээс гадна тухайн цаг үеийн дүр төрх, үзэл суртал, үнэт зүйлийг хадгалсан зурагт хуудас, ухуулга сурталчилгааны материалууд өргөнөөр

хэвлэгдэх болсон байна. 1921 оны Ардын хувьсгалаас эхлэн социализмын үе, улмаар ардчилсан шилжилтийн үе хүртэл зурагт хуудас нь улс төр, соёл, нийгмийн хөдөлгөөнийг олон нийтэд хүргэх, тухайн үеийн визуал соёлын хөгжлийг илэрхийлэх чухал эх сурвалж болж хөгжсөн юм.

Зурагт хуудасны типографи буюу үсгийн дизайн нь мэдээлэл дамжуулах үүргээс гадна бүтээлийн утга санаа, агуулга, уур амьсгал, бэлгэдлийг илэрхийлэх чухал үүрэгтэй. Монгол бичиг нь босоо бичлэгийн онцлогтой тул зурагт хуудасны зохиомжид кирилл болон латин үсгээс ялгаатай харааны өвөрмөц бүтцийг бий болгодог. Монгол бичиг 1941 он хүртэл Монгол Улсын албан хэрэглээний бичиг байсан боловч тухайн үеийн улс төр, боловсролын бодлогын хүрээнд кирилл үсгийг албан ёсны бичиг болгон нэвтрүүлсэн байдаг (Чулуунбаатар 2002, 2006). Гэсэн хэдий ч монгол бичиг соёл, урлагийн хэрэглээнээс бүрэн алга болоогүй бөгөөд ном хэвлэл, дүрслэх урлаг, зурагт хуудас зэрэг бүтээлүүдэд тодорхой хэмжээгээр ашиглагдсаар ирсэн байна.

Монгол бичгийн хэлбэр зүй, уран бичлэг, бичгийн түүхийн талаар монголын судлаачид цөөнгүй судалгаа хийсэн байдаг. Тухайлбал, Д.Батбаяр болон Д.Цэрэнпил нар монгол бичгийн үсгийн хэлбэр, уран бичлэгийн уламжлал, соёлын хэрэглээний талаар судалсан (Батбаяр 2015; Цэрэнпил 2018) бол, урлаг судлаач Ц.Эрдэнэцог ХХ зууны монголын зурагт хуудасны үүсэл хөгжил, улс төр, соёлын чиг үүрэг, төрөл зүйл, хувьслыг түүхэн хөгжлийн үүднээс судалсан байна (Эрдэнэцог 2023). Гэвч эдгээр судалгаанууд нь ихэвчлэн бичиг үсгийн түүх, уран бичлэг, зурагт хуудсыг урлагийн талаас нь авч үзсэн бөгөөд монгол бичгийн типографийг график дизайны үүднээс, ялангуяа семиотикийн онолын хүрээнд системтэй шинжилсэн судалгаа харьцангуй ховор байна. Тэр дундаа монгол бичгийн типографи зурагт хуудасны зохиомжид ямар байр суурь эзэлж байсан, ямар утга агуулга бүтээж байсан, тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөхцөл байдалтай хэрхэн холбогдон хувьсан өөрчлөгдөж ирсэн асуудал төдийлөн судлагдаагүй хэвээр байна.

Олон улсын судалгаанд “типографи нь визуал харилцааны чухал элемент гэж үздэг бөгөөд үсгийн хэлбэр нь бэлгэдлийн болон сэтгэл хөдлөлийг илэрхийлэх боломжтой” (Bringhurst 2008, 99) гэж тайлбарладаг. Мөн “График дизайн нь утга дамжуулах тэмдэгтийн систем бөгөөд текст болон дүрслэл нь хамтдаа дүрслэлийн хэлний нэг хэсгийг бүрдүүлдэг” (Barnard 2005, 11) гэж үзжээ. Энэхүү онолын хандлага нь монгол бичгийг зөвхөн текст гэдэг агуулгаар бус, харин утга бүтээх тэмдэгтийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх боломжийг олгож байна.

Монгол Улс 2025 оноос төрийн албан хэрэгт кирилл болон монгол бичгийг хослуулан хэрэглэх бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь үндэсний бичгийн хэрэглээг орчин үеийн визуал орчинд дахин тодорхойлох шинэ хэрэгцээг бий болгож байна (Монгол Улсын Засгийн газар 2020). Гэвч монгол бичгийн типографийн түүхэн хөгжлийг график дизайны болон семиотикийн үүднээс тайлбарласан судалгаа цөөн байгаа нь орчин үеийн хэрэглээг онолын түвшинд ойлгоход тодорхой хоосон зай үүсгэж байна. Иймээс ХХ зууны зурагт хуудас дахь монгол бичгийн хэрэглээг семиотикийн үүднээс шинжлэх нь түүний дүрслэлийн боломж, утга илэрхийллийн онцлог, соёлын үүргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаанд монгол бичгийг график дизайны тэмдэгтийн тогтолцооны нэг хэсэг хэмээн авч үзэж, 1921-2000 оны хооронд бүтээгдсэн монгол бичиг бүхий 60 зурагт хуудсыг Чарльз Моррисийн семиотикийн гурвалсан загвар (синтактик, семантик, прагматик)-ын хүрээнд шинжилж, монгол бичгийн типографи, зохиомж, өнгөний хэрэглээ, хэвлэлийн технологийн онцлог болон утга илэрхийллийн шинжийг тодорхойлохыг зорив. Энэхүү зорилгын хүрээнд: (1) зурагт хуудасны зохиомж дахь монгол бичгийн синтактик бүтцийг тодорхойлох; (2) монгол бичгийн типографийн семантик буюу утга илэрхийлэх онцлогийг шинжлэх; (3) хэвлэлийн технологи болон хэрэглээний орчны нөлөөг прагматик түвшинд тайлбарлах; (4) судалгааны үр дүнд тулгуурлан монгол бичгийн типографийн хөгжлийн онцлогийг нэгтгэн дүгнэж, орчин үеийн график дизайн дахь хэрэглээний ач холбогдлыг тодорхойлох зорилтуудыг дэвшүүлэв.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд чанарын судалгааны аргыг ашиглаж, визуал контент шинжилгээ болон семиотик шинжилгээний аргыг хослуулан хэрэглэв. Судалгааны онолын үндэс нь Америкийн философич Чарльз Моррисийн 1938 онд хэвлүүлсэн “Foundations of the Theory of Signs” бүтээлдээ дэвшүүлсэн семиотикийн гурвалсан загвар юм. Моррис семиотикийг тэмдэг болон түүний бүтэц (синтактик), утга (семантик), хэрэглээ (прагматик)-ний харилцан хамаарлыг судалдаг шинжлэх ухаан хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү загвар нь график дизайны бүтээлүүдийн утга бүтээх механизмыг системтэй шинжлэх онолын боломжийг бүрдүүлдэг (Morris 1938, 6-7).

Синтактик түвшинд монгол бичгийн үсгийн байршил, зохиомж дахь харилцаа, үсгийн хэв маягийн онцлогийг; семантик түвшинд үсгийн тиг, өнгө, дүрслэлийн бэлгэдлийн утгыг; харин прагматик түвшинд зурагт хуудасны хэрэглээний орчин, хэвлэлийн технологи болон тухайн цаг үеийн нийгмийн нөхцөлтэй холбоотой хэрэглээг тус тус шинжилсэн болно.

Судалгаанд 1921-2000 оны хооронд бүтээгдсэн монгол бичиг бүхий нийт 60 зурагт хуудсыг зорилтот түүврийн аргаар сонгон авч ашиглав. Энэхүү арга нь судалгааны зорилготой шууд холбоотой, тодорхой шинжийг агуулсан хэрэглэгдэхүүнийг сонгон шинжлэх боломж олгодог тул тохиромжтой гэж үзэв. Судалгааны материалыг Ц.Эрдэнэцогийн “XX зууны Монголын зурагт хуудас: түүхэн хөгжлийн тойм”, Ирья Халаш болон Б.Мэнд-Амар нарын “Шилжилтийн үеийн зурагт хуудас”, “XX зууны Монголын соёл, урлагийн зурагт хуудсууд” зэрэг номын эх сурвалжаас бүрдүүлэв.

Судалгаанд дараах шалгуурыг хангасан зурагт хуудсыг сонгон авч хамруулав. Үүнд: (1) монгол бичгийг гарчиг болон үндсэн текстэд ашигласан байх; (2) бүтээгдсэн он нь тодорхой байх; (3) дүрслэлийн чанар нь шинжилгээ хийхэд чанартай байх; (4) XX зууны өөр өөр түүхэн үе болон сэдэвчилсэн төрлийг төлөөлөх боломжтой байх зэрэг шалгуурыг баримталсан болно. Эдгээр шалгуур нь XX зууны монгол бичгийн типографийн хэрэглээний үндсэн хэв шинжийг төлөөлөх түүврийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Судалгаанд сонгосон 60 зурагт хуудсыг улс төр, нийгэм, соёлын нөхцөл байдалтай уялдуулан гурван үндсэн үед ангилав.

Хүснэгт 1. Судалгаанд ашигласан зурагт хуудасны түүхэн үечлэл

Түүхэн үе	Тоо (60)	Онцлог
1921-1940	8 (13%)	Уламжлалт босоо зохиомж, дармал тиг давамгай
1941-1989	25 (42%)	Социалист ухуулга, кирилл үсгийн албан хэрэглээ, монгол бичгийн хэрэглээ багассан үе
1990-2000	27 (45%)	Ардчилал, шинэ хэвлэлийн технологи, өнгө болон зохиомжийн шинэ туршилтууд

1921-1940 оны зурагт хуудас харьцангуй цөөн байгаа нь тухайн үед зурагт хуудас хязгаарлагдмал хэмжээгээр хэвлэгдэж байсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь архивын сан хөмрөгт бүрэн хадгалагдаж үлдээгүйтэй холбоотой.

Цуглуулсан 60 зурагт хуудсыг 01-60 хүртэл дугаарлан мэдээллийн сан бүрдүүлж, бүтээгдсэн он, зохиогч, сэдэв, өнгөний хэрэглээ, үсгийн хэв маяг, хэвлэлийн технологи зэрэг үзүүлэлтээр кодлон бүртгэв. Улмаар бүрдүүлсэн өгөгдлийг Моррисийн семиотикийн загварын хүрээнд синтактик, семантик, прагматик түвшинд ангилан шинжилж, монгол бичгийн үсгийн хэлбэр, утга илэрхийллийн онцлог, хэрэглээний хувьслыг тодорхойлон дүгнэв.

Судалгааны үр дүн

XX зууны монголын зурагт хуудсыг шинжлэхэд монгол бичгийн типографи нь зохиомжийн бүтэц, үсгийн хэв маяг, өнгөний шийдэл, хэвлэлийн технологийн хувьд цаг үеэ даган хувьсан өөрчлөгдөж ирсэн нь ажиглагдав. Судалгааны үр дүнг Моррисийн семиотикийн гурвалсан загварын дагуу синтактик, семантик, прагматик гэсэн гурван түвшинд авч үзлээ.

1. Синтактик буюу үсгийн зохиомж ба хэлбэр

Синтактик түвшний шинжилгээ нь монгол бичгийн типографийн зохиомж дахь байрлал, үсгийн хэлбэр, өнгө, тигийн хэрэглээг авч үзэхэд чиглэв. Судалгаанд ашигласан нийт 60 зурагт хуудасны 55 (92%) нь босоо, 5 (8%) нь хэвтээ зохиомжтой байсан нь монгол бичгийн босоо бичлэгийн уламжлал зурагт хуудасны ерөнхий зохиомжид нөлөөлж байсныг харуулж байна.

Текстийн байрлалын тархалтыг (Зураг 1) авч үзэхэд монгол бичиг нь нийт зурагт хуудасны 18%-д зохиомжийн дээд хэсэгт, 13%-д доод хэсэгт, 10%-д төв хэсэгт байрласан байна. Монгол бичгийн босоо бүтцийн онцлогоос шалтгаалан текстийг зурагт хуудасны зүүн болон баруун хэсэгт босоо чиглэлээр байрлуулах хандлага түгээмэл ажиглагдсан. Тухайлбал, нийт зурагт хуудасны 28%-д текстийг зүүн талд, 24%-д баруун талд, 7%-д зүүн болон баруун талд зэрэгцүүлэн байрлуулсан байна. Энэ нь бичгийн бичлэгийн чиглэл нь зохиомжийн бүтэц, текстийн байрлалын шийдэлд нөлөөлж, монгол бичгийг зурагт хуудасны харааны зохион байгуулалтын чухал бүрэлдэхүүн болгон ашиглаж байсныг илтгэнэ.

Зурагт хуудасны агуулгаас шалтгаалан текстийн үүрэг харилцан адилгүй байв. Улс төрийн болон кино сурталчилгааны төрлийн зурагт хуудаст график дүрслэл давамгай байр суурь эзэлж, текст нь тайлбарлах шинжтэйгээр байрласан бол

соёл, урлагийн сэдэвт бүтээлд монгол бичгийг гол төлөв зохиомжийн гол элемент болгож ашигласан байна.



Зураг 1. Зурагт хуудас дахь монгол бичгийн текстийн байрлал

Монгол бичгийн тигийг бичмэл болон дармал гэсэн үндсэн хоёр хэлбэрт хувааж үздэг (Цэрэнпил 2015, 26). Судалгаанд ашигласан зурагт хуудсыг түүхэн үеэр ангилан шинжлэхэд 1921-1989 оны зурагт хуудсанд дармал тиг давамгай хэрэглэгдсэн бол 1990 оноос хойш бичмэл тигийн хэрэглээ нэмэгдсэн нь ажиглагдав (Хүснэгт 2). Эхэн үеийн зурагт хуудасны үсэг нь өргөн нуруутай, зураасны зузааны ялгарал ихтэй байсан бол 1990 оноос хойш үсгийн хэлбэр илүү чөлөөтэй, уран сайхны шинжтэй болсон байна.

Өнгөний хэрэглээ нь зурагт хуудасны зохиомжийн бүтцийн нэг хэсэг болж байв. Судалгаанд хамруулсан зурагт хуудсыг харахад 1921-1989 оны бүтээлүүдэд улаан өнгө давамгай байсан бол 1990 оноос хойш өнгөний сонголт илүү төрөлжсөн хандлага ажиглагдав. Энэхүү ялгаа нь зурагт хуудас хэвлэх технологийн хөгжилтэй холбоотой гэж үзэж болно. XX зууны эхэн болон дунд үед зурагт хуудсыг ихэвчлэн гараар зурах, торгон хэвлэл, барлах зэрэг харьцангуй хязгаарлагдмал өнгө ашиглах боломжтой аргаар хэвлэж байсан тул цөөн өнгийн шийдэл давамгайлж байжээ. Харин 1990 оноос хойш дижитал болон олон өнгийн хэвлэлийн технологи нэвтэрснээр өнгөний сонголт өргөжиж, зурагт хуудасны харааны зохиомжид олон өнгийг хослуулан ашиглах боломж бүрдсэн байна.

Хүснэгт 2. XX зууны зурагт хуудас дахь монгол бичгийн үсгийн дүрслэл

Үе	1921-1940	1941-1989	1990-2000
Зурагт хуудас	8	25	27
Тиг	Дармал 100%	Дармал 92% Бичмэл 8%	Дармал 67% Бичмэл 33%

Үндсэн зураас	Өргөн нуруу Зураасны ялгарал их	Өргөн нуруу Зураасны ялгарал их	Үсгийн зузааны ялгарал бага
Хүрээ	Байгаа-2	Байгаа-3	Байгаа-4
Сүүдэр	Сүүдэртэй – 25% Сүүдэргүй – 75%	Сүүдэртэй – 4% Сүүдэргүй – 96%	Сүүдэртэй – 11% Сүүдэргүй – 89%

Нэмэлт чимэглэлийн элементүүдийг судлахад нийт зурагт хуудасны 17 (28%) нь хүрээ, сүүдэр, үсгийн суналт, хэлбэрийн өөрчлөлт зэрэг график аргыг ашигласан байна (Зураг 2). Үүнээс 59% нь хүрээ болон сүүдрийн элемент хэрэглэсэн бол 41% нь үсгийн хэлбэрийг өөрчлөх, сунгах зэргээр илэрхийлжээ.



Зураг 2. Нэмэлт чимэглэл ашигласан зурагт хуудасны жишээ

Эдгээр шийдэл нь монгол бичгийг зохиомжийн илэрхийллийн элемент болгон ашиглах хандлага байсныг харуулж байна. Ялангуяа XX зууны төгсгөл үеийн зурагт хуудсанд үсгийн хэлбэрийг дүрслэлийн элементтэй уялдуулан өөрчлөх туршилтууд нэмэгдсэн нь ажиглагдав.


2. Семантик буюу утга зүйн илэрхийлэл

Семантик түвшний шинжилгээ нь зурагт хуудас дахь монгол бичгийн типографи ямар утга, бэлгэдэл, соёлын агуулга бүтээж байсныг тодорхойлоход чиглэв.

Судалгаанд сонгосон зурагт хуудасны үсгийн тигийн хэрэглээ нь агуулгатайгаа тодорхой хамааралтай байгааг ажиглаж болно. Дармал тиг нь тогтвортой, зураасны бүтэц нь жигд учир ихэвчлэн улс төрийн ухуулга, сурталчилгааны зурагт хуудсанд хэрэглэсэн бол бичмэл тиг нь уран сайхны илэрхийлэл, үндэсний хэв шинжийг тодотгох боломжтой учир урлаг, соёлын сэдэвтэй бүтээлүүдэд түгээмэл ашиглажээ.

Үсгийн хэлбэр нь зөвхөн текстийн үүрэг гүйцэтгэхээс гадна дүрслэлийн нэг хэсэг болсон жишээ цөөнгүй байна. Ийм төрлийн үсгийн хэрэглээг орчин үеийн дизайн судлалд “экспрессив буюу илэрхийлэмжтэй типографи” (expressive typography) гэж нэрлэдэг бөгөөд энэ нь текстийг мэдээлэл дамжуулах хэрэгсэл төдийгүй график дүрслэлийн хэлбэрээр санааг илэрхийлэхэд ашигладаг (Turgut 2017, 164). Жишээлбэл, зураг 3-т харуулсан “Сэрүүн дуганы мөхөл” киноны зурагт хуудаст гарчгийн үсгийн хэлбэр нь утгын илэрхийлэлтэй уялдсан байна. Үсгийн суналт (үгийн төгсгөлийн “н” болон “л” үсэг), үсгээс унаж байгаа нулимс

нь киноны сэдэвтэй холбоотой уналт, доройтол, эмгэнэлт өнгө аясыг илэрхийлсэн байна.



Зураг 3. Илэрхийлэмжтэй типографи

“Хөхөлдэй хүүгийн үлгэр” жүжгийн зурагт хуудаст монгол бичгийн гарчиг нь мангасын дүрийн хөдөлгөөн, дүрслэлийн бүтэцтэй уялдуулж текст болон дүрслэлийг нэгтгэсэн байна. Мөн “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” зурагт хуудаст бүрээнээс гарч байгаа текстийг уриа хэлбэрт оруулан график болгон дүрсэлж үзүүлжээ. “Морин жилийн Монгол” зурагт хуудасны үсгийн хэлбэрийг морин дүрслэлтэй нэгтгэснээр текст өөрөө бэлгэдлийн дүрслэл болон хувирсан байна. Цэнхэр, цагаан өнгө нь морин жилийн “мандал бадрал, хийморь” гэх соёлын бэлгэдэлтэй семантик түвшинд нийцэж байна. Монгол бичгийн хэлбэр, бүтэц нь утга бүтээх визуал тэмдэгтийн тогтолцоо болж байсныг харуулж байна.

Зурагт хуудасны агуулгын ангиллыг авч үзэхэд нийт түүврийн 40% нь улс төрийн, 60% нь урлаг, соёлын агуулгатай байв. Улс төрийн зурагт хуудаст монгол бичиг нь ихэвчлэн уриа, үзэл суртлын агуулгыг дэмжих үүрэгтэй байсан бол урлаг, соёлын зурагт хуудсанд үндэсний өв, уламжлал, соёлын үнэт зүйлсийг илэрхийлэх бэлгэдлийн шинж давамгайл байв (Зураг 4).



Зураг 4. Улс төрийн сэдэвт зурагт хуудаснууд

Зурагт хуудасны утга зүйн түвшинд өнгө нь агуулга болон бэлгэдлийг илэрхийлэх чухал үүрэг гүйцэтгэж байв. 1921-1989 оны зурагт хуудсанд улс төрийн үзэл суртлын нөлөөгөөр улаан өнгө зонхилж байсан бол 1990 оноос хойш хөх, цэнхэр өнгөний хэрэглээ нэмэгдсэн нь монголчуудын уламжлалт ертөнцийг үзэх үзэл, үндэсний бэлгэдэлтэй холбоотой байв. Судлаач С.Дуламын тэмдэглэснээр түүхэн хөгжлийн явцад хөх өнгө нь улс төр, түүх, соёл, шүтлэгийн олон давхар утга агуулсан бэлгэдэл болон төлөвшсөн байна (Дулам 2011, 23). Иймээс өнгөний хэрэглээний энэхүү өөрчлөлт нь тухайн үеийн нийгэм, соёлын үнэт зүйл, бэлгэдлийн тогтолцооны хувьсалтай уялдсан байна.


Монгол бичгийн тиг, хэлбэр, өнгө, дүрслэлийн уялдаа нь зурагт хуудасны утга бүтээх үйл явцад оролцож, агуулга, бэлгэдэл, соёлын үнэт зүйлсийг илэрхийлэх чухал семантик хэрэгсэл болж байжээ.

3. Прагматик буюу хэрэглээний орчин

Прагматик шинжилгээ нь тэмдгийн хэрэглээ болон хэрэглэгчийн хоорондын харилцааг судалдаг (Morris 1938, 7). Судалгаанд прагматик түвшний шинжилгээг хийхдээ зурагт хуудасны хэрэглээний орчин, зорилтот үзэгч, хэвлэлийн технологи зэрэг хүчин зүйлсийг авч үзэв.

Судалгаанд ашигласан зурагт хуудсыг ажиглахад XX зууны эхэн үеийн бүтээлүүдэд гараар зурсан шинж давамгайл байсан бол хожуу үеийн зурагт хуудсанд хэвлэлийн технологийн хөгжлийг даган дүрслэл, зохиомжийн шийдэл улам боловсронгуй болсон (Эрдэнэцог 2023, 136, 207) (Хүснэгт 3).

*Хүснэгт 3. Хэвлэлийн технологийн хөгжил ба монгол бичгийн
типографид үзүүлсэн нөлөө*

Он	Голчлон хэрэглэж байсан хэвлэлийн технологи	Шинж чанар	Жишээ
1921-1940	Гараар зурах	Зурагт хуудсыг гараар бүтээж байсан тул бичмэл шинж давамгай. Үсгийн зураас зузаан, өргөн, хэлбэртэй.	
1941-1989	Торгон хэвлэл, Барлах	Үсгийн хэлбэр илүү тогтворжиж, том хэмжээний гарчиг болон өндөр контраст бүхий шийдэл түгээмэл хэрэглэгдэх болсон.	
1990-2000	Дижитал, торгон хэвлэл	Үсгийн тигийн сонголт өргөжиж, өнгө, зохиомж болон илэрхийлэмжтэй типографийн шийдлийг хэрэгжүүлэх боломж нэмэгдсэн.	

Хэвлэлийн технологийн хөгжил нь монгол бичгийн үсгийн хэлбэр, хэрэглээний боломжид шууд нөлөөлж байв. Гараар зурсан болон уламжлалт хэвлэлийн аргаар бүтээсэн зурагт хуудаст өргөн нуруутай, зузаан зураастай үсэг давамгай хэрэглэгдэж байсан бол дижитал технологи нэвтэрснээр үсгийн хэлбэрийг илүү нарийн боловсруулж, олон төрлийн тиг ашиглаж, илэрхийлэмжтэй типографийн шийдлийг хэрэгжүүлэх боломж нэмэгдсэн байна.

Зурагт хуудсыг ихэвчлэн хот, аймаг, сумын төвийн соёлын байгууллага, театр, үйлдвэрийн байр болон олон нийтийн гудамж талбайд байршуулж байв (Эрдэнэцог 2023, 161). Ийм орчинд зурагт хуудсыг холоос харах, богино хугацаанд мэдээлэл дамжуулах шаардлага байдаг тул том хэмжээний гарчиг, өнгөний ялгарал сайтай шийдэл, өргөн зураастай үсгийн хэлбэрийг түлхүү ашиглаж байжээ.

Текстын уншигдах байдал нь харах зай, өнцөг, гэрэлтүүлэг зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаардаг (Cai, Green 2009, 280). Иймээс зурагт хуудасны типографийн шийдэл нь мэдээллийг олон нийтэд үр дүнтэй хүргэх прагматик шаардлагатай холбоотой байв. Монгол бичгийн үсгийн хэмжээ, зураасны зузаан, өнгөний ялгарал зэрэг шийдлүүд нь тухайн үеийн хэрэглээний орчин болон үзэгчдийн хэрэгцээнд нийцүүлдэг байв.

Монгол бичгийн типографийн хөгжил нь зөвхөн үсгийн хэлбэрийн өөрчлөлтөөр хязгаарлагдахгүй, харин хэвлэлийн технологи, хэрэглээний орчин, үзэгчдийн хэрэгцээтэй нягт уялдан хөгжиж ирсэн нь харагдаж байна.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгааны үр дүнг Чарльз Моррисийн семиотикийн гурвалсан загварын хүрээнд авч үзэхэд XX зууны монголын зурагт хуудас дахь монгол бичиг нь утга бүтээх визуал тэмдэгтийн тогтолцоо болж хөгжсөн нь харагдаж байна. Синтактик, семантик, прагматик түвшний шинжилгээний үр дүнг нэгтгэн үзвэл монгол бичгийн хэлбэр, зохиомж, өнгө, хэрэглээний орчин нь харилцан уялдаатайгаар зурагт хуудасны утга илэрхийллийг бүрдүүлж байжээ.

Синтактик түвшинд монгол бичгийн босоо бичлэг нь зурагт хуудасны зохиомжийн бүтцэд нөлөөлж байжээ. Барууны уламжлалт зурагт хуудасны хэвтээ бүтэцтэй харьцуулахад монгол бичгийн босоо хэлбэр нь текстийг зохиомжийн хажуу тэнхлэгт байрлуулах, дүрслэлийн элементтэй нэгтгэх боломжийг бүрдүүлжээ. Энэ нь монгол бичгийн хэлбэр өөрөө визуал зохиомжийн нэг хэсэг болжээ.

Семантик түвшний шинжилгээнээс харахад монгол бичгийн тиг, хэлбэр болон дүрслэлийн уялдаа нь тухайн бүтээлийн агуулгыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байв. Зурагт хуудсанд үсгийн хэлбэрийг дүрслэлийн элементтэй нэгтгэн ашигласан нь утга бүтээх нэмэлт боломжийг бүрдүүлжээ. Өнгөний хэрэглээний хувьсал нь мөн тухайн үеийн нийгэм, соёлын өөрчлөлттэй уялдан тайлбарлагдаж байна. Судалгаанд ашигласан зурагт хуудсанд социализмын үед улаан өнгө давамгай хэрэглэгдэж байсан бол XX зууны төгсгөл үеэс хөх, цэнхэр өнгөний хэрэглээ нэмэгдсэн нь үндэсний бэлгэдэл, уламжлалт соёлын үнэт зүйлсийг дахин тодотгох хандлагатай холбоотой гэж үзэж болно. Үүнтэй адилаар 1990 оноос хойш зурагт хуудасны агуулга нь улс төрийн ухуулгаас хэрэглээ, соёл, урлагийн чиглэл рүү өргөжсөн нь ажиглагдсан бөгөөд энэ нь ардчиллын дараах нийгэм-соёлын өөрчлөлттэй холбоотой байв (Эрдэнэцог 2023, 177). Зурагт хуудасны өнгө, дүрслэл, агуулгын өөрчлөлт нь тухайн үеийн нийгмийн үнэт зүйл, соёлын чиг хандлагын өөрчлөлттэй нягт уялдаж байсан гэж үзэж болно.

Прагматик түвшинд авч үзэхэд зурагт хуудасны дизайн нь тухайн үеийн хэвлэлийн технологи болон хэрэглээний орчноос хамаарч байсан ба хот, суурин газрын олон нийтийн орчинд байрлуулах шаардлага нь том хэмжээний гарчиг, өндөр контраст бүхий өнгө, холоос уншигдахуйц үсгийн хэлбэрийг сонгоход нөлөөлжээ. Үүнээс үзэхэд монгол бичгийн типографийн хөгжил нь технологи, хэрэглээний орчин, нийгмийн хэрэгцээтэй уялдан өөрчлөгдөж ирсэн байна.

Энэхүү судалгааны үр дүн нь олон улсын типографийн судалгааны зарим дүгнэлттэй нийцэж байна. Тухайлбал, Bringhurst үсгийн хэлбэр нь зөвхөн мэдээлэл дамжуулах бус, тодорхой утга санаа, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх боломжтой (Bringhurst 2008, 99) гэж үзсэн байдаг. Судалгаанд ашигласан зурагт хуудсанд үсгийн хэлбэрийг дүрслэлийн элементтэй нэгтгэн ашигласан нь энэхүү үзэл баримтлалтай нийцэж байна. Мөн Turgut-ийн илэрхийлэмжтэй типографийн талаарх судалгаанд текстийг график дүрслэлийн нэг хэсэг болгон ашиглах нь

утга бүтээх чухал хэрэгсэл болдог гэж дүгнэсэн (Turgut 2017, 164) бөгөөд энэхүү судалгаанд шинжилсэн “Сэрүүн дуганы мөхөл”, “Хөхөлдэй хүүгийн үлгэр”, “Морин жилийн Монгол” зэрэг зурагт хуудсанд илэрсэн шийдлүүд нь уг хандлагыг монголын зурагт хуудасны жишээн дээр баталж байна. Иймээс монгол бичгийн типографи нь зөвхөн бичгийн мэдээлэл дамжуулах хэрэгсэл бус, визуал утга бүтээх тэмдэгтийн тогтолцооны нэг хэсэг болж байсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Судалгааны шинэлэг тал нь XX зууны монголын зурагт хуудасны монгол бичгийн типографийг Чарльз Моррисийн семиотикийн гурвалсан загварын хүрээнд синтактик, семантик, прагматик түвшинд системтэй шинжилсэнд оршино. Өмнөх судалгаанууд ихэвчлэн монгол бичгийн түүх, уран бичлэг, эсвэл зурагт хуудасны урлагийн хөгжлийг тус тусад нь авч үзэж байсан бол энэхүү судалгаа нь монгол бичгийн хэлбэр, утга илэрхийлэл болон хэрэглээний орчны харилцан хамаарлыг нэгтгэн тайлбарласнаараа онцлог юм. Иймээс зурагт хуудасны монгол бичгийн типографийн хөгжлийг визуал соёл, график дизайны судалгааны хүрээнд тайлбарлах шинэ боломжийг бүрдүүлж байна.

Судалгааны үр дүнгийн үнэмшлийг нэмэгдүүлэх зорилгоор XX зууны өөр өөр түүхэн үеийг төлөөлөх нийт 60 зурагт хуудсыг сонгон шинжилсэн нь монгол бичгийн типографийн хэрэглээний нийтлэг хандлагыг тодорхойлох боломж олгосон хэдий ч зарим хязгаарлалт бий. Тухайлбал, XX зууны эхэн үеийн зурагт хуудасны архивын материал хязгаарлагдмал байгаа нь тухайн үеийн бүх төрлийн хэвлэмэл бүтээлийг бүрэн хамруулах боломжийг хязгаарласан. Мөн судалгаа нь чанарын шинжилгээнд тулгуурласан тул үр дүнг бүх зурагт хуудсанд ерөнхийлөн хэрэглэхээс илүүтэйгээр тухайн түүхэн үеийн нийтлэг шинжийг тодорхойлсон гэж үзэх нь зүйтэй. Цаашид илүү өргөн хэмжээний түүвэр болон тоон шинжилгээний аргыг хавсран ашиглах нь монгол бичгийн типографийн хөгжлийг илүү нарийвчлан тодорхойлох боломжтой юм.

Монгол Улс хос бичгийн хэрэглээг албан бичгийн түвшинд хэрэглэж буй өнөө үед энэхүү судалгааны үр дүн нь орчин үеийн график дизайн дахь монгол бичгийн хэрэглээг ойлгох онолын үндэс болох боломжтой юм. Түүнчлэн үндэсний бичгийг орчин үеийн визуал орчинд хэрхэн үр дүнтэй ашиглах талаар цаашдын судалгаанд суурь мэдээлэл болж чадна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар 1921-2000 оны хооронд бүтээгдсэн монгол бичиг бүхий 60 зурагт хуудсыг Чарльз Моррисийн семиотикийн гурвалсан загварын хүрээнд шинжилж, монгол бичгийн үсгийн хэлбэр, утга илэрхийлэл болон хэрэглээний орчны онцлогийг тодорхойлов.

Судалгааны үр дүнгээс харахад, синтактик түвшинд монгол бичгийн босоо бичлэг нь зурагт хуудасны зохиомжийн бүтцэд онцгой нөлөө үзүүлж, текстийг дүрслэлийн элементтэй уялдуулан байрлуулах өвөрмөц боломжийг бүрдүүлж байжээ. Үсгийн тиг, хэлбэр, чимэглэлийн хэрэглээ нь XX зууны туршид нийгэм, соёлын өөрчлөлттэй уялдан хувьсаж, XX зууны төгсгөл үеэс илүү чөлөөт, уран сайхны илэрхийлэмжтэй болсон байна.

Семантик түвшний шинжилгээнээс үзэхэд монгол бичгийн тиг, хэлбэр болон дүрслэлийн уялдаа нь зурагт хуудасны агуулгыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байв. Үсгийн хэлбэрийг дүрслэлийн элементтэй нэгтгэн ашигласан нь утга бүтээх нэмэлт боломжийг бүрдүүлж, монгол бичгийн дүрслэлийн нөөц боломжийг харуулсан байна. Мөн өнгөний хэрэглээ нь тухайн цаг үеийн нийгэм, соёлын үнэт зүйл, бэлгэдлийн тогтолцоотой уялдан өөрчлөгдөж байжээ.

Прагматик түвшинд авч үзэхэд хэвлэлийн технологийн хөгжил болон зурагт хуудасны хэрэглээний орчин нь монгол бичгийн типографийн хөгжилд шууд нөлөөлсөн байна. Гараар зурдаг уламжлалт аргаас дижитал технологид шилжсэнээр үсгийн хэлбэр, өнгөний хэрэглээ, зохиомжийн шийдэлд шинэ боломжууд бий болжээ.

Ийнхүү XX зууны монголын зурагт хуудсанд монгол бичиг нь зохиомж, утга илэрхийлэл, хэрэглээний орчны түвшинд харилцан уялдсан визуал систем болон хөгжиж ирсэн нь тогтоогдов. Энэхүү судалгаа нь монгол бичгийн типографийг семиотикийн үүднээс тайлбарлах онолын үндсийг өргөжүүлэхийн зэрэгцээ монголын визуал соёл, график дизайны түүхийг судлахад шинэ өнцөг санал болгож байна. Цаашдын судалгаанд кирилл болон монгол бичгийн типографийн харьцуулсан шинжилгээ хийх, орчин үеийн дижитал орчин дахь монгол бичгийн хэрэглээний онцлогийг судлах нь монголын визуал соёлын судалгаанд шинэ боломж нээх юм.

Ашигласан материалын жагсаалт

- Батбаяр, Д. 2015. *Монгол уран бичлэгийн түүх. Тэргүүн дэвтэр*. Улаанбаатар: Соёмбо Пресс.
- Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Битпресс
- Монгол Улсын Засгийн газар. 2020. *Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III*. Улаанбаатар.
- Халаш, Ирья, Мэнд-Амар, Б. 2022. *Шилжилтийн үеийн Монголын зурагт хуудас*. Улаанбаатар: Адмон Принт.
- Цэрэнпил, Д. 2018. *Үсэг бичгийн урлаг*. Улаанбаатар.
- Чулуунбаатар, Л. 2002. *Нүүдэлчин монголчуудын үсгийн соёл*. Улаанбаатар.
- Эрдэнэцог, Ц. 2023. *Монголын зурагт хуудас - XX зуун: Түүхэн хөгжлийн тойм*. Улаанбаатар.
- XX зууны Монголын соёл урлагийн зурагт хуудсууд. 2025. Эмх. Мэнд-Амар Б. Улаанбаатар: Броскод Пабблишинг.
- Barnard, Malcolm. 2005. *Graphic Design as Communication*. London: Routledge.
- Bringhurst, Robert. 2008. *The Elements of Typographic Style*. 3rd ed. Point Roberts, WA: Hartley & Marks.

- Cai, Hongyi, and Paul Green. 2009. "Legibility Index for Examining Common Viewing Situations: A New Definition Using Solid Angle." *LEUKOS* 5 (4): 279-295.
- Morris, Charles W. 1938. *Foundations of the Theory of Signs*. Chicago: University of Chicago Press.
- Turgut, Özden Pektaş. 2017. "Expressive Typography as a Visualization of Ideas." *New Trends and Issues Proceedings on Humanities and Social Sciences* 4 (11): 164-170.